

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын
Халамжийн сангийн /улсын төсөв/ 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/250-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
2023 он	Аудитор: Д.Чулуунцэцэг Утас: 7036-2442 Цахим хаяг: Chuluuntsetsegd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

–	
1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4-8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	9-11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
4. Аудитын тайлан	12-14
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Материаллаг байдал	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. Аудитын илрүүлэлт	15
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА Л.ЗОРИГТБААТАР ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2023.02.17 № 00А-2023/250-НАСАГМЗ

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн /улсын төсөв/ 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн /улсын төсөв/ 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Халамжийн санд /улсын төсөв/ эхний 1 сарын байдлаар улсын төсвөөс 59,435.9 мянган төгрөгийн санхүүжилт олгогдож, гүйцэтгэлээр 2709 иргэнд 59,134.2 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгогдож, 301.7 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд нийгмийн халамжийн үйлчилгээг Нийгмийн халамжийн нэгдсэн цахим системд шилжүүлж, ХХҮЕГ-аас санхүүжилтийг шууд олгож эхэлсэнтэй холбоотойгоор Сэлэнгэ аймгийн ХХҮГ-ын ахмад настанд үзүүлэх тусламж хөнгөлөлт, тэтгэвэр, асаргааны тэтгэмж, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлт, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний харилцах данснуудыг 2022 оны 1 дүгээр сарын 31-ны өдрөөр тасалбар болгон хаасан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө		
31200	Банканд байгаа бэлэн мөнгө		
31210	Төгрөг		
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
33	АВЛАГА		
33500	Бусад авлага		
34	УРЬДЧИЛГАА		
35	БАРАА МАТЕРИАЛ		
35100	Түүхий эд материал		
35400	Хангамжийн материал		
36	НӨӨЦИЙН БАРАА		
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		
39200	Биет хөрөнгө		
39300	Биет бус хөрөнгө		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		
51	Засгийн газрын хувь оролцоо		
51200	Хуримтлагдсан үр дүн		
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		

/Төгрөгөөр/

4317143998
MICA0005-905-436

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	/Төгрөгөөр/	
			Тайлант оны гүйцэтгэл	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,253,465,500.00	63,935,870.00	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	780,500.00	4,500,000.00	
120	Нийтлэг татварын бус орлого	780,500.00	4,500,000.00	
120002	Хүүгийн орлого	-		
120009	Бусад орлого	780,500.00	4,500,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,252,685,000.00	59,435,870.00	
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,252,685,000.00	59,435,870.00	
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,252,685,000.00	59,435,870.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,253,465,500.00	63,935,870.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,253,465,500.00	63,935,870.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,761,550.00	00.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,761,550.00	00.00	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,761,550.00	00.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,251,703,950.00	63,935,870.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,146,943,276.50	59,134,170.00	
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	5,146,943,276.50	59,134,170.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	104,760,673.50	4,801,700.00	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	104,760,673.50	4,801,700.00	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	-	-	
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	=	=	

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /	
					Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл					
5	Тайлант үеийн үр дүн					
6	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл					
7	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл					
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл					
9	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл					

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>5,253,465,500.00</u>	<u>63,935,870.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	780,500.00	4,500,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	780,500.00	4,500,000.00
120002	Хүүгийн орлого	-	-
120009	Бусад орлого	780,500.00	4,500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,252,685,000.00	59,435,870.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,252,685,000.00	59,435,870.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,252,685,000.00	59,435,870.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>5,253,465,500.00</u>	<u>63,935,870.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,253,465,500.00	63,935,870.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,761,550.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,761,550.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,761,550.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,251,703,950.00	59,435,870.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,146,943,276.50	59,134,170.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	5,146,943,276.50	59,134,170.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	104,760,673.50	4,801,700.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	104,760,673.50	4,801,700.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=====	=====
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

/Төгрөгөөр/

Ашиг
Хүндэтгэл
МОНГО
Улаанбаатар

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	59,435,900.00	59,134,170.00	301,730	98.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	59,435,900.00	59,134,170.00	301,730	98.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	00.00	00.00	00.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	00.00	00.00	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	00.00	00.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	00.00	00.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	00.00	00.00	
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	59,435,900.00	59,134,170.00	301,730	98.9
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	59,435,900.00	59,134,170.00	301,730	98.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	59,435,900.00	59,134,170.00	301,730	98.9
131001	Улсын төсвөөс санхүүжих	59,435,900.00	59,134,170.00	301,730	98.9
3	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийгмийн халамжийн тухай хуульд зааснаар Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сан /Цаашид Халамжийн сан гэх/ -ийн үйл ажиллагааны зорилго, зорилт, чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, нийгмийн халамжийн талаар төрөөс баримталж буй цогц бодлогыг орон нутагт чанартай, хүртээмжтэй, шуурхай хүргэх замаар иргэдийн хөдөлмөрлөх, хөгжих таатай орчин бий болгож, амьжиргааны түвшинг дээшлүүлэх.
- Хүн амын зорилтот бүлгүүдийн хэрэгцээнд тулгуурлан нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх замаар нийгмийн халамж хүртэгчээс хөдөлмөр эрхлэгч болох нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэх.


3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна.

Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 362 дугаар тушаалаар “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журам”-ыг шинэчлэн баталсан,
- Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн “Судалгааны үзэл баримтлал, аргачлал, асуулгын маягт, асуулга нөхөх заавар батлах тухай” А/84, А/89 дугаар хамтарсан тушаал гарсан,
- Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Жагсаалт, шалгуур үзүүлэлт, маягт шинэчлэн батлах тухай” А/807, А/216 дугаар хамтарсан тушаал гарсан,
- ХХҮЕГ-ын даргын 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн А/155 дугаар “Гэрээний загвар батлах тухай” тушаалаар гэрээний загварыг шинэчилсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.



Халамжийн сангийн санхүүгийн үйл ажиллагаанд ХХҮЕГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс хяналт тавьж ажилладаг боловч тайлант онд дотоод хяналт шалгалт, аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэх ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

4317143998
МЮА0065 9055436

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Халамжийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ХХҮЕГ-ын даргын 2018 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн А/174 дүгээр тушаалаар ХХҮЕГ-ын болон түүний харьяа байгууллагын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд


Халамжийн сангийн 2022 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлд “Нийгмийн халамжийн сан нь мөнгөн хөрөнгийн сан байна” гэж заасны дагуу халамжийн сангийн хөрөнгө нь зөвхөн мөнгөн хөрөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөөс бүрдэж байна. Өөрөөр хэлбэл Халамжийн сангийн санхүүгийн тайланд бараа материал, үндсэн хөрөнгө зэрэг хөрөнгийн бусад хэлбэрүүд тусгагдаагүй байна.

Тайлант оны 02 дугаар сараас нийгмийн халамжийн үйлчилгээг “Нийгмийн халамжийн нэгдсэн цахим систем”-д шилжүүлж, ХХҮЕГ-аас санхүүжилтийг шууд олгож эхэлсэнтэй холбоотойгоор Халамжийн сангийн санхүүгийн үр дүнгийн

тайлангаарх нийт орлого, зарлага өмнөх оны гүйцэтгэлээс 5,189,529.6 мянган төгрөгөөр буюу 98.8 хувиар буурч, 63,935.9 мянган төгрөгөөр тайлагнагдсан байна.



3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сангийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг тус бүр 1,739,148.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж, батлуулсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,739,148.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас нийгмийн халамжийн үйлчилгээг Нийгмийн халамжийн нэгдсэн цахим системд шилжүүлсэнтэй холбогдуулан 1-р сарын төсвийн 59,435.9 мянган төгрөгийн санхүүжилтийг аймгийн ХХҮГ, 2-12 дугаар сарын төсвийн 1,679,712.1 мянган төгрөгийг ХХҮЕГ захиран зарцуулсан байна.

Аймгийн ХХҮГ-ын захиран зарцуулсан төсвийн нийт зардлын гүйцэтгэл 59,134.2 мянган төгрөг буюу 99.4 хувьтай байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламжаас 130.0 мянган төгрөг, хүнс тэжээлийн дэмжлэг тусламжаас 168.0 мянган төгрөг, ахмад настны хөнгөлөлтийн санхүүжилтээс 3.7 мянган төгрөг хэмнэгдэж, улсын төсөвт буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Аймгийн ХХҮГ-ын захиран зарцуулсан хөрөнгийн батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулбал:

Хүснэгт 1. Сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл


/мянган төгрөгөөр/					
д/д	Сангийн зарцуулалт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	59,435.9	59,134.2	301.7	99.4
2	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	59,435.9	59,134.2	301.7	99.4
3	Улсын төсвөөс санхүүжих	59,435.9	59,134.2	301.7	99.4
4	Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлтийн зардал	20,000.0	19,996.3	3.7	99.9
5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	10,803.9	10,673.9	130.0	98.7
6	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт	28,632.0	28,464.0	168.0	99.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Халамжийн сангийн / улсын төсөв / 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.



Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн халамжийн сангаас олгож байгаа тэтгэвэр, тэтгэмжийн хувийн хэргийн бүрдэл болон байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд асаргааны тэтгэмжийг олгоход байгуулсан гэрээ болон гэрээний дүгнэлтэд өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Чулуунцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Халамжийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/71 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.


Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 5,252,685.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 52,526.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ. / Хэдийгээр аймгийн Халамжийн сангаар 59,134.9 мянган төгрөгийг зарцуулсан боловч ХХҮЕГ-аас шууд олгосон санхүүжилтийн зарцуулалтын холбогдох баримт, материалыг аудитад хамруулсан /

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант оны эхэнд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 442 өрхийн 2525 гишүүн иргэн хамрагдаж байснаас хөдөлмөр эрхлэх чадвартай, орлого багатай иргэдийг халамжаар бус ажил эрхлэлтээр дэмжин сургалтад хамруулан ажилд зуучилснаар 110 өрхийн 641 гишүүн иргэн уг үйлчилгээнээс хасагдаж 37,620.0 мянган төгрөг хэмнэгдсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.



4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Сэлэнгэ аймгийн ХХҮГ-ын мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээллээс тухай бүрд мэдээлэх тайлант жилийн төсөвт орсон, нэмэлт, өөрчлөлтийн / 2 сард / 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай / бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт/ нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар 3 дугаар улирлын санхүүгийн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “Амьжиргаа дэмжих зөвлөл”-ийн хурлаар хэлэлцсэн асуудлыг бүх гишүүдийн гарын үсгээр баталгаажуулж байх, шийдвэрийг тэтгэвэр, тэтгэмжийн хувийн хэрэгт хавсаргаж байх, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд асаргааны тэтгэмж олгохтой холбогдсон гэрээг зохих журмын дагуу байгуулан, цахим системд оруулаагүй зэрэг 3 зөрчилд зөвлөмж өгснийг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт


/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	-	3	-	100.0
Нийт дүн	3	-	3	-	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан бүх сумдад хүрч ажиллах боломжгүй учир Баянгол, Ерөө, Зүүнбүрэн, Орхон, Түшиг зэрэг 5 сумын ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний санхүүжилт, түүний зарцуулалт, цахим хувийн хэргийг түүвэрлэн шалгалаа.

Санхүүгийн тайлангийн аудитад тус халамжийн сангийн няглан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой асуудлыг бүрэн хамруулсан бөгөөд халамжийн сангаас олгож байгаа тэтгэвэр, тэтгэмжид хамрагдаж байгаа иргэдийн цахим хувийн хэрэг, тэтгэвэр, тэтгэмж тогтоолтыг иж бүрэн тулган баталгаажуулах боломжгүй тул цаашид гүйцэтгэл, нийцлийн аудитаар авч үзэх шаардлагатай юм.



5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2 зөрчил илэрч, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:



1. Тэтгэвэр, тэтгэмжийн хувийн хэргийн бүрдэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Баянгол, Ерөө, Зүүнбүрэн, Орхон, Түшиг зэрэг байнгын асаргаатай иргэдэд асаргааны тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг зохицуулах зарим гэрээнд амьжиргаа дэмжих зөвлөлийн шийдвэрийг дурдаагүй, хугацааг тодорхойлоогүй, сунгалтыг хийгээгүй, гэрээг баталгаажуулалгүйгээр цахим хувийн хэрэгт хавсаргасан бөгөөд гэрээг цахим системд оруулж аймгийн ХХҮГ-т илгээгээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 362 дугаар тогтоолын 1 дугаар хавсралтаар батлагдсан "Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа олгох журам"-ын 2.5, 2.6, 8.10 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Байнгын асаргааны тэтгэмж олгохтой холбоотой гэрээг зохих хууль журмын дагуу байгуулан баталгаажуулж, нийгмийн халамжийн нэгдсэн цахим системд оруулж байх.

2. Гэрээний биелэлттэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Баянгол, Ерөө, Зүүнбүрэн, Сүхбаатар, Орхон, Түшиг зэрэг сумдын эмнэлгийн хяналтад байдаг байнгын асаргаа шаардлагатай иргэний асаргааны тэтгэмж олгохтой холбоотой "Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асрах тухай гэрээ"-ний биелэлтийг батлагдсан актаар дүгнээгүй байна.

Энэ нь ХХҮЕГ-ын даргын 2022 оны А/155 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асрах тухай гэрээ"-ний 5.2-т "Энэхүү гэрээг талууд бүх шатандаа чанд биелүүлэн ажиллах бөгөөд үйлчилгээний явц, гэрээний биелэлтийг хагас жил тутамд хамтран хэлэлцэж дүгнэнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асрах тухай гэрээний биелэлтийг хагас жил тутамд батлагдсан актаар дүгнэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

4317143998
МЮА/065 9055430

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо
Баримтыг бүрэн бүрдүүлээгүй	1						1						
Гэрээг холбогдох актаар дүгнээгүй	1						1						
Дүн	2						2						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								